



## Бурхан биднийг зэвсгэлдэг Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

**Мөн чанар: Бурхан биднийг зэвсгэлдэг**

**Attribute: God Equips**

**Тодорхойлолт:** Тодорхой нэг зорилго, нөхцөл байдалд тохируулан шаардлагатай зүйлсээр хангах, оюун санааны болон сэтгэлзүйн хувьд бэлтгэх, бэлэн болгох

**Эшлэл(үүд):**

- **Дуулал 18:31-32** ЭЗЭНЭЭС өөр хэн Бурхан юм бэ? Бидний Бурханаас өөр хэн хад вэ? Хүч чадлаар намайг бүсэлдэг Бурхан Замыг минь төгс болгодог.
- **Ефес 4:11-12** Тэр, заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайнмэдээ тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгосон нь ариун хүмүүсийн үйлчлэлийн ажилд бэлтгэж, Христийн биеийг байгуулахын тулд юм.
- **2 Тимот 3:16-17** Бичвэр бүр Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай. Энэ нь Бурханы хүн чадамгай, аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм.
- **2 Петр 1:3** Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

*Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9*

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

**Өөрсдийн хүүхдүүдийн төлөө** — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

**Эшлэл(үүд):** Еврей 13:20-21

**Библийн эшлэлээр залбирах:**

Хоньдын Хоньчин болох бидний Эзэн Есүсийг мөнх гэрээний цусаар үхэгсдээс амилуулсан амар амгалангийн Бурхан Өөрийнх нь хүслийг гүйцэтгэх аливаа сайн хэрэгт (Хүүхдийн нэр)-ыг бэлэн болгож, Өөрийнхөө мэлмийд тааламжтай зүйлийг (Хүүхдийн нэр)-ий дотор бүтээлгэхээр Есүс Христээр дамжуулан ажиллаж байна. Есүс Христэд алдар нь [үеийн] үед байх болтугай. Амен.

**Залбирлын тодорхой хүсэлт:**

**Багш/Ажилчид** (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та \_\_\_\_\_-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн үүчлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- Хоньдын Хоньчин болох бидний Эзэн Есүсийг мөнх гэрээний цусаар үхэгсдээс амилуулсан амар амгалангийн Бурхан Өөрийнх нь хүслийг гүйцэтгэх аливаа сайн хэрэгт \_\_\_\_\_-ыг бэлэн болгож, Өөрийнхөө мэлмийд тааламжтай зүйлийг \_\_\_\_\_-ий дотор бүтээлгэхээр Есүс Христээр дамжуулан ажиллаж байна. Есүс Христэд алдар нь [үеийн] үед байх болтугай. Амен. *Еврей 13:20-21*

**Сургуулийн төлөө залбирах** – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

**Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах** — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

*Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!*